



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Овоо сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/91/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Цэрэнчимэд

Утас: 88302569 Цахим хаяг: tserenchimedb@sudit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.ЖАВЗАНСҮРЭН
ТАНАА 7

2019.02.25 № 2/70

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\СТА-2018\Баян-Овоо сумын ЗДТГазар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2519121

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\СТА-2018\Баян-Овоо сумын ЗДТГазар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГазрын дарга М.Жавзансүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 31-нээс 2019 оны 02 дугаар сарын 04-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн

баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баян-Овоо сумын ЗДТГазрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баян-Овоо сумын ЗДТГазар нь “Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, ард иргэдэд төрийн үйлчилгээг байнгын тасралтгүй үзүүлж, шударга ёсыг эрхэмлэн дээдлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Баян-Овоо сумын ЗДТГазрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баян-Овоо сумын ЗДТГазрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Баян-Овоо сумын ЗДТГазрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баян-Овоо сумын ЗДТГазар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох групп ХХК-ий "Acolous" программ хангамж ашигладаг байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баян-Овоо сумын ЗДТГазрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод БНА-2019/91/СТА-ТШЗ

хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэж байна.

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн нь 463090,2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 9261,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	6.20	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	6.20	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалт, нотлох баримтын бүрдүүлэлтийн талаар Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг хатуу мөрдөж ажиллах шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баян-Овоо сумын ЗДТГазрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 314113,3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 293799,0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарснаас 20314,3 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг тусад нь авч ажлын баримтад хавсаргасан болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баян-Овоо сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 18 байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100,0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баян-Овоо сумын ЗДТГазрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын баримтын бүрдэл хангалтгүй, ихэнх мөнгийг шагнал урамшилд болон нутгийн зөвлөлийн уулзалт, багуудын өдөрлөг гэх мэт үр ашиггүй зүйлд зарцуулсан зөрчил илэрлээ

Энэ нь “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан " Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" -ын 2.1-ийг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ нь тодорхой хугацааны явцад бодитойгоор болж өнгөрсөн, гүйцэтгэсэн байдлыг төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1 дэх заалтыг хэрэгжүүлж,

хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, нотлох баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,294,350.00</u>	<u>62,218,000.00</u>
33	АВЛАГА	00.00	1,600,000.00
335	Бусад авлага	00.00	1,600,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,600,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,294,350.00	60,618,000.00
351	Түүхий эд материал	250,000.00	250,000.00
35110	Тусгай зориулалттай материал	250,000.00	250,000.00
354	Хангамжийн материал	15,044,350.00	60,368,000.00
35410	Бичиг хэргийн материал	749,100.00	2,164,000.00
35420	Аж ахуйн материал	777,250.00	599,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	680,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	208,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	12,630,000.00	57,605,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>854,315,133.06</u>	<u>1,362,569,067.35</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	854,315,133.06	1,362,569,067.35
392	Биет хөрөнгө	854,341,633.08	1,301,841,567.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	744,919,208.00	1,188,138,812.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-241,678,717.90	-111,699,673.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	145,942,168.00	133,304,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-93,081,522.58	-88,567,985.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,909,097.40	176,846,484.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-66,424,901.36	-77,780,770.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,362,112.00	50,704,021.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,868,684.04	-25,811,203.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	329,001,673.58	108,764,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-124,538,800.02	-57,856,917.05
39216	Дуусаагүй барилга, байгууламж	5,800,000.00	5,800,000.00
393	Биет бус хөрөнгө	-26,500.02	60,727,499.98
39301	Програм хангамж	265,000.00	265,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-291,500.02	-291,500.02
39303	Бусад биет бус хөрөнгө	450,000.00	60,754,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>869,609,483.06</u>	<u>1,424,787,067.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>399,015.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	399,015.00	00.00
413	Өглөг	399,015.00	00.00

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	14,215.00	00.00
4136	Бусад өглөг	384,800.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	114,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	270,800.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	869,210,468.06	1,424,787,067.35
51	Засгийн газрын хувь оролцоо	869,210,468.06	1,424,787,067.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	464,955,281.22	525,709,281.22
51101	Өмч: - төрийн	464,955,281.22	525,709,281.22
512	Хуримтлагдсан үр дүн	358,579,037.41	574,628,444.33
51210	Өмнөх үеийн үр дүн	358,579,037.41	358,579,037.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	216,049,406.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,676,149.43	324,449,341.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	869,609,483.06	1,424,787,067.35

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	388,267,344.00	726,574,400.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,177,467.00	410,800,473.71
120	Нийтлэг татварын бус орлого	12,177,467.00	410,800,473.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,112,000.00	410,800,473.71
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	1,281,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,452,000.00	409,518,973.71
120009	Бусад орлого	65,467.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,089,877.00	315,773,927.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,178,206.00	23,256,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,178,206.00	23,256,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	294,930,800.00	292,517,527.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	294,930,800.00	292,517,527.00
1330	Төсвийн захирагчдаас	56,796,600.00	00.00
133003	Хөрөнгийн	56,796,600.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,184,271.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,184,271.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	386,723,154.86	463,090,228.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,957,304.86	463,090,228.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,565,355.96	453,839,082.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,110,299.01	157,600,601.00
210101	Үндсэн цалин	162,010,299.01	157,600,601.00
210105	Гэрээт ажлын хөлс	100,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,001,399.69	18,961,171.90
210201	Тэтгэврийн даатгал	18,001,399.69	12,783,214.34
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,576,005.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,165,496.83
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	284,442.76
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,152,011.98

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,736,583.00	22,755,836.00
210301	Гэрэл, цахилгаан	2,798,283.00	3,100,236.00
210302	Түлш, халаалт	11,938,300.00	19,655,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,598,653.00	46,850,312.00
210401	Бичиг хэрэг	6,291,630.00	7,842,130.00
210402	Тээвэр, шатахуун	24,131,648.00	30,126,027.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,025,000.00	3,564,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,659,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,150,375.00	2,658,355.00
2105	Нормативт зардал	405,000.00	550,000.00
210502	Хоол, хүнс	405,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	550,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,062,600.00	3,890,200.00
210604	Урсгал засвар	10,062,600.00	3,890,200.00
2107	Томилолт, зочны зардал	4,118,600.00	3,061,000.00
210702	Дотоод албан томилолт	4,118,600.00	3,061,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,401,878.40	75,620,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,273,838.40	75,562,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	599,740.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,300.00	18,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	40,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,130,342.86	124,549,211.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,328,000.00	37,663,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,062,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,802,342.86	85,823,381.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,391,948.90	9,251,146.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,105,271.00	9,249,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,184,271.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,221,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	8,769,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,700,000.00	480,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	72,539.26	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,539.26	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	214,138.64	1,846.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	214,138.64	1,846.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,765,850.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,765,850.00	00.00
223001	Бусад хөрөнгө	4,765,850.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,544,189.14	263,484,172.51
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	47,434,765.59
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	545,001.53
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	46,889,764.06
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-47,434,765.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,544,189.14	216,049,406.92

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	320,018,744.00	317,055,427.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	725,467.00	1,281,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	725,467.00	1,281,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	660,000.00	1,281,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	1,281,500.00
120009	Бусад орлого	65,467.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	319,293,277.00	315,773,927.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,178,206.00	23,256,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,178,206.00	23,256,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	294,930,800.00	292,517,527.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	294,930,800.00	292,517,527.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,184,271.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,184,271.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	320,018,744.00	309,665,427.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	320,018,744.00	309,665,427.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,626,795.10	300,414,280.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,172,728.05	154,295,969.06
210101	Үндсэн цалин	150,394,870.05	154,295,969.06
210105	Гэрээт ажлын хөлс	11,777,858.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,001,399.69	19,347,057.16
210201	Тэтгэврийн даатгал	18,001,399.69	13,027,262.61
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,584,546.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,204,528.72
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	306,695.62
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,224,024.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,764,836.00	22,586,376.00
210301	Гэрэл, цахилгаан	2,340,536.00	2,930,776.00
210302	Түлш, халаалт	11,424,300.00	19,655,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,230,324.00	28,830,569.00
210401	Бичиг хэрэг	3,098,424.00	1,489,920.00
210402	Тээвэр, шатахуун	21,882,300.00	26,494,189.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,756,420.00	846,460.00
210404	Ном, хэвлэл	215,080.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	278,100.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,457,600.00	733,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,507,000.00	110,600.00
210602	Тавилга	10,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	9,950,600.00	622,600.00
2107	Томилолт, зочны зардал	3,907,800.00	3,271,800.00
210702	Дотоод албан томилолт	3,907,800.00	3,271,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,092,107.36	27,296,371.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,964,067.36	24,515,871.68

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	599,740.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,300.00	18,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,722,500.00
210807	Газрын төлбөр	90,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	44,052,938.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	38,978,538.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	5,074,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,391,948.90	9,251,146.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,105,271.00	9,249,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,184,271.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,221,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	8,769,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,700,000.00	480,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	72,539.26	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,539.26	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	214,138.64	1,846.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	214,138.64	1,846.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	7,390,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	7,390,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	7,390,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	7,390,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	7,390,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-7,390,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,955,281.22	45,676,149.43	358,579,037.41	869,210,468.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	464,955,281.22	45,676,149.43	358,579,037.41	869,210,468.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	278,773,192.37	00.00	278,773,192.37
Тайлант үеийн үр дүн	60,754,000.00	00.00	216,049,406.92	276,803,406.92
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,709,281.22	324,449,341.80	574,628,444.33	1,424,787,067.35

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	314,113,300.00	293,797,720.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,113,300.00	293,797,720.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,144,000.00	284,548,420.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,435,300.00	154,295,969.06
210101	Үндсэн цалин	163,435,300.00	154,295,969.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,612,200.00	19,347,057.16
210201	Тэтгэврийн даатгал	13,235,400.00	13,027,262.61
210202	Тэтгэмжийн даатгал	1,594,200.00	1,584,546.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,275,300.00	1,204,528.72
210204	Ажилгүйдлийн даатгал	318,900.00	306,695.62
210205	Эрүүл мэндийн даатгал	3,188,400.00	3,224,024.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,587,300.00	22,586,376.00
210301	Гэрэл, цахилгаан	2,694,900.00	2,930,776.00
210302	Түлш, халаалт	19,892,400.00	19,655,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,722,700.00	28,830,569.00
210401	Бичиг хэрэг	1,495,400.00	1,489,920.00
210402	Тээвэр, шатахуун	28,273,500.00	26,494,189.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	953,800.00	846,460.00
2105	Нормативт зардал	106,600.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	106,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,736,000.00	2,733,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,110,600.00
210604	Урсгал засвар	736,000.00	622,600.00
2107	Томилолт, зочны зардал	5,425,700.00	3,271,800.00
210702	Дотоод албан томилолт	5,425,700.00	3,271,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,448,200.00	5,040,511.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,390,200.00	1,260,011.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,000.00	18,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	3,722,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,070,000.00	48,442,938.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,070,000.00	38,978,538.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	9,464,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,969,300.00	9,249,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,969,300.00	9,249,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,769,300.00	8,769,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	480,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	314,113,300.00	293,797,720.22
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	313,513,300.00	292,516,220.22

Баян-Овоо сумын ЗДТГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Орон нутгийн төсвөөс	313,513,300.00	292,516,220.22
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	1,281,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	1,281,500.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15	15
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6
620003	Үйлчлэх ажилтан	2	2